

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын-ын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2025/075/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsogui@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/206  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЦЭНД-АЮУШ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны А/63 дугаар тушаалаар нийт 54,549.0 мянган төгрөгийн 10 нэр төрлийн 52 ширхэг тоног төхөөрөмж, 19,600.0 мянган төгрөгийн авто машиныг шилжүүлэн асан, төсвийн хөрөнгөөр 12,797.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 123,084.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 33,134.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан бэлтгээгүй, цахим системд нийтлээгүй, төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг 6,498.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн, хоолны зардалд 71,152.0 мянган төгрөг зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн.

#### Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын ажлын албаны дарга нь аймгийн ИТХ-ын даргаар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжүүлэн ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,056,427.00</b>	<b>29,576,672.00</b>
33	АВЛАГА	202,055.00	00.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	14,854,372.00	29,576,672.00
354	<b>Хангамжийн материал</b>	14,854,372.00	29,576,672.00
35410	Бичиг хэргийн материал	1,679,256.00	1,976,756.00
35420	Аж ахуйн материал	3,355,630.00	12,262,930.00
35430	Сэлбэг хэрэгсэл	692,200.00	1,001,200.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	840,000.00
35450	Барилгын засварын материал	241,000.00	1,145,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,886,286.00	12,350,786.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>275,016,155.91</b>	<b>413,268,622.26</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	275,016,155.91	413,268,622.26
392	<b>Биет хөрөнгө</b>	222,139,767.07	412,733,205.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,587,620.00	3,587,620.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,494,841.81	-1,793,810.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	199,980,000.00	226,877,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,783,333.29	-90,822,949.91
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,740,600.00	261,979,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,906,563.18	-46,410,919.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,345,028.00	62,479,233.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,878,742.65	-22,312,267.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,000,000.00	24,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,450,000.00	-4,850,000.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	52,876,388.84	535,416.60
39301	Програм хангамж	2,941,667.00	2,941,667.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,515,278.16	-2,406,250.40
39303	Бусад биет бус хөрөнгө	51,450,000.00	00.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>290,072,582.91</b>	<b>442,845,294.26</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>290,072,582.91</b>	<b>442,845,294.26</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	290,072,582.91	442,845,294.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	186,071,105.00	134,621,105.00
51101	Өмч: - төрийн	186,071,105.00	134,621,105.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	104,001,477.91	308,224,189.26
51210	Өмнөх үеийн үр дүн	104,001,477.91	104,001,477.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	204,222,711.35
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>290,072,582.91</b>	<b>442,845,294.26</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,683,942,266.72</b>	<b>2,125,750,670.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>145,818,666.72</b>	<b>74,149,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	145,818,666.72	74,149,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,818,666.72	74,149,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	145,818,666.72	74,149,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,538,123,600.00</b>	<b>2,051,601,670.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	307,922,000.00	256,865,870.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,230,201,600.00	1,794,735,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,230,201,600.00	1,794,735,800.00

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,532,171,572.38</b>	<b>1,917,751,037.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,532,171,572.38</b>	<b>1,917,751,037.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,177,574,263.45</b>	<b>1,408,861,084.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>306,074,968.47</b>	<b>408,789,104.19</b>
210101	Үндсэн цалин	179,365,912.30	232,789,913.04
210102	Нэмэгдэл	68,751,265.72	135,463,691.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,680,000.00	22,880,000.00
210104	Урамшуулал	34,277,790.45	17,655,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,259,371.20</b>	<b>51,867,538.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,016,372.41	35,195,873.93
210202	Тэтгэмжийн даатгал	3,060,749.69	4,140,691.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,448,599.70	2,291,881.14
210204	Ажилгүйдлийн даатгал	612,149.95	1,314,980.31
210205	Эрүүл мэндийн даатгал	6,121,499.45	8,924,111.63
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,280,281.40</b>	<b>81,961,410.79</b>
210401	Бичиг хэрэг	3,940,000.00	12,140,550.00
210402	Тээвэр, шатахуун	24,239,900.00	46,745,647.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,602,781.40	3,406,603.79
210404	Ном, хэвлэл	576,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,921,600.00	19,668,610.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,652,400.00</b>	<b>11,445,450.00</b>
210604	Урсгал засвар	9,652,400.00	11,445,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,700,000.00</b>	<b>58,668,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,700,000.00	58,668,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>339,875,022.00</b>	<b>376,741,974.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	336,918,554.00	371,919,506.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,000.00	586,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,468.00	134,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	2,618,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>426,732,220.38</b>	<b>419,387,607.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	330,980,640.00	327,662,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,797,280.00	42,040,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,954,300.38	49,684,817.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>354,597,308.93</b>	<b>508,889,952.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>319,622,980.00</b>	<b>323,830,570.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	319,622,980.00	323,830,570.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>34,974,328.93</b>	<b>185,059,382.94</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,974,328.93	185,059,382.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>151,770,694.34</b>	<b>207,999,633.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>49,196,289.22</b>	<b>3,776,921.65</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	49,196,289.22	3,776,921.65
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-49,196,289.22</b>	<b>-3,776,921.65</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>102,574,405.12</b>	<b>204,222,711.35</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,538,123,600.00</b>	<b>2,051,601,670.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,538,123,600.00</b>	<b>2,051,601,670.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>307,922,000.00</b>	<b>256,865,870.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	00.00

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	304,922,000.00	256,865,870.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,230,201,600.00</b>	<b>1,794,735,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,230,201,600.00	1,794,735,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,471,670,295.00</b>	<b>1,882,586,465.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,471,670,295.00</b>	<b>1,882,586,465.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,117,072,986.07</b>	<b>1,377,751,512.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>306,277,023.47</b>	<b>408,587,049.19</b>
210101	Үндсэн цалин	179,567,967.30	232,587,858.04
210102	Нэмэгдэл	68,751,265.72	135,463,691.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,680,000.00	22,880,000.00
210104	Урамшуулал	34,277,790.45	17,655,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,259,371.20</b>	<b>51,867,538.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,016,372.41	35,195,873.93
210202	Тэтгэмжийн даатгал	3,060,749.69	4,140,691.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,448,599.70	2,291,881.14
210204	Ажилгүйдлийн даатгал	612,149.95	1,314,980.31
210205	Эрүүл мэндийн даатгал	6,121,499.45	8,924,111.63
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>39,730,281.40</b>	<b>62,864,260.79</b>
210401	Бичиг хэрэг	3,940,000.00	13,554,150.00
210402	Тээвэр, шатахуун	24,239,900.00	34,585,647.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,602,781.40	3,406,603.79
210404	Ном, хэвлэл	576,000.00	376,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,371,600.00	10,941,060.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>630,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	630,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,652,400.00</b>	<b>19,581,450.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	6,726,000.00
210604	Урсгал засвар	9,652,400.00	12,855,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,700,000.00</b>	<b>58,668,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,700,000.00	58,668,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>339,956,030.00</b>	<b>422,622,334.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	336,999,562.00	417,929,866.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,000.00	586,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,468.00	134,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	2,488,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>364,497,880.00</b>	<b>352,930,880.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	330,980,600.00	310,890,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,517,280.00	42,040,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>354,597,308.93</b>	<b>504,834,952.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>319,622,980.00</b>	<b>319,775,570.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	319,622,980.00	319,775,570.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>34,974,328.93</b>	<b>185,059,382.94</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,974,328.93	185,059,382.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>66,453,305.00</b>	<b>169,015,205.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>66,453,305.00</b>	<b>169,015,205.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>66,453,305.00</b>	<b>169,015,205.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>66,453,305.00</b>	<b>169,015,205.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	66,453,305.00	169,015,205.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-66,453,305.00</b>	<b>-169,015,205.00</b>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	134,621,105.00	1,427,072.79	136,048,177.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,621,105.00	1,427,072.79	136,048,177.79
C07	Тайлант үеийн үр дүн	51,450,000.00	102,574,405.12	154,024,405.12
C08	2023оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,071,105.00	104,001,477.91	290,072,582.91
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	186,071,105.00	104,001,477.91	290,072,582.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,071,105.00	104,001,477.91	290,072,582.91
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-51,450,000.00	00.00	-51,450,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	204,222,711.35	204,222,711.35
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	308,224,189.26	442,845,294.26

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,794,735,800.00	1,609,676,417.06	185,059,382.94	89.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,794,735,800.00	1,609,676,417.06	185,059,382.94	89.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,731,792,800.00	1,546,766,717.06	185,026,082.94	89.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,893,600.00	408,587,049.19	153,306,550.81	72.7
210101	Үндсэн цалин	274,647,900.00	232,587,858.04	42,060,041.96	84.7
210102	Нэмэгдэл	219,400,100.00	135,463,691.15	83,936,408.85	61.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,960,000.00	22,880,000.00	14,080,000.00	61.9
210104	Урамшуулал	30,885,600.00	17,655,500.00	13,230,100.00	57.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,236,700.00	51,867,538.08	18,369,161.92	73.8
210201	Тэтгэврийн даатгал	47,761,000.00	35,195,873.93	12,565,126.07	73.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,618,900.00	4,140,691.07	1,478,208.93	73.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,495,100.00	2,291,881.14	2,203,218.86	51.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,123,800.00	1,314,980.31	-191,180.31	117.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,237,900.00	8,924,111.63	2,313,788.37	79.4
2104	Хангамж, бараа материалын зардал	63,805,800.00	62,864,260.79	941,539.21	98.5
210401	Бичиг хэрэг	13,560,000.00	13,554,150.00	5,850.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	34,715,000.00	34,585,647.00	129,353.00	99.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,200,000.00	3,406,603.79	793,396.21	81.1
210404	Ном, хэвлэл	376,800.00	376,800.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,954,000.00	10,941,060.00	12,940.00	99.9
2105	Нормативт зардал	804,000.00	630,000.00	174,000.00	78.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	804,000.00	630,000.00	174,000.00	78.4

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	149,824,000.00	149,679,450.00	144,550.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	103,824,000.00	103,824,000.00	0.00	100.0
210602	Тавилга	33,000,000.00	33,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	13,000,000.00	12,855,450.00	144,550.00	98.9
2107	Томилолт, зочны зардал	60,000,000.00	58,668,000.00	1,332,000.00	97.8
210702	Дотоод албан томилолт	60,000,000.00	58,668,000.00	1,332,000.00	97.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	467,228,700.00	461,539,539.00	5,689,161.00	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	462,448,200.00	456,847,071.00	5,601,129.00	98.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	586,000.00	586,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,500.00	134,468.00	32.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,576,000.00	2,488,000.00	88,000.00	96.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	358000000.00	352930880.00	5,069,120.00	98.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	311,000,000.00	310,890,880.00	109,120.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	47,000,000.00	42,040,000.00	4,960,000.00	89.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62943000.00	62909700.00	33,300.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,943,000.00	62,909,700.00	33,300.00	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,943,000.00	62,909,700.00	33,300.00	99.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,794,735,800.00	1,609,676,417.06	185,059,382.94	89.7
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,794,735,800.00	1,609,676,417.06	185,059,382.94	89.7
132001	Орон нутгийн төсвөөс	1,794,735,800.00	1,609,676,417.06	185,059,382.94	89.7
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	10.00	10.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	0.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		256,865,870.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		256,865,870.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		256,865,870.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		256,865,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		256,865,870.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		256,865,870.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		256,865,870.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		256,865,870.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 77,650.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 77,650.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 71,050.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын хугацаанд залруулсан. Үүнд:

- Өмчид бүртгэсэн 51,450.0 мянган төгрөгийн газрын эрхийг шилжүүлэхдээ үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэж өмчийн дүнг бууруулаагүй.
- Шинэ-Мөрөн ХХК-иас шилжүүлэн авсан 19,600.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй hyundai sonata 8 маркийн Авто машиныг үндсэн хөрөнгөнд бүртгэж орлогод аваагүй байсныг тус тус залруулан.

### Төлбөрийн акт

Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын төсвөөс 21,202.3 мянган төгрөгийн архи, согтууруулах ундаа, 371.9 мянган төгрөгийн вакуус, шар тайлагч, бэлэн гоймон бусад хүнсний материал бэлтгэж, нийт 21,574.2 мянган төгрөгийг хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар, зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хугацаанд зориулалт бусаар зарцуулсан 21,574.2 мянган төгрөгийг Төрийн сангийн Хө.Бусад нэр заагдаагүй орлого 100170000955 тоот дансанд тушааж төсөвт учирсан хохирлыг бүрэн барагдуулсан.

### Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Худалдан авах ажиллаатай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан бэлтгээгүй, цахим системд нийтлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах" журмын 2.1-т "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна" гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны тухай хууль, журмыг мөрдөж худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах.

#### 2. Төлөөлөгчийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа үйлчилгээний бусад зардал 21090102 данснаас төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг нийт 6,498.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын хавсралтаар баталсан жишигтэй нийцэхгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг нийтлэг жишиг нормативаас хэтрүүлэхгүй байх.

#### 3. Зардлын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 31,858,500 төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардлын данснаас 25,173.5 мянган

төгрөгийг сургалтын хоолны зардалд, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 14,120.0 мянган төгрөгийг хурлын хуралдааны хоолны зардалд тус тус зарцуулсан. Сургалт, хуралдааны хоолны зардалд нийт 71,152.0 мянган төгрөгийг зарцуулсан нь төсвийн үр ашгийг бууруулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.үр ашигтай байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвөөс сургалт, хуралдааны хоолны зардал гаргахгүй байж, төсвийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулах.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НББ-ийн тооцооллын алдаа	2	71,050.0	1	19,600.0	1	51,450.0	2	71,050.0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>71,050.0</b>	<b>1</b>	<b>19,600.0</b>	<b>1</b>	<b>51,450.0</b>	<b>2</b>	<b>71,050.0</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг хэтрүүлэн зарцуулсан	1	6,498.0					1	6,498.0
Төсвийг сургалт, хуралдааны хоолны зардалд зарцуулсан	1	71,152.0					1	71,152.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>77,650.0</b>					<b>2</b>	<b>77,650.0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааны хууль журмыг баримтлаагүй	1				1	
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>	